

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
ШИНЖЛЭХ УХААНЫ СУРГУУЛЬ
“МОНГОЛ СУДЛАЛ”

Эрдэм шинжилгээний сэтгүүл

Боть L (626)

<https://doi.org/10.22353/ms20255004>

ХАРИЛЦАА ЯРИАН ДАХЬ ЭРЭГТЭЙ, ЭМЭГТЭЙ ХҮНИЙ ХАРИУ
ҮЙЛДЭЛ ҮЗҮҮЛЭХ ҮГ ХЭЛЛЭГИЙН ХЭРЭГЛЭЭ

П.Буянцогт
Ж.Ганбаатар

Түлхүүр үг: Монгол хэл, нийгэм хэл шинжлэл, хэл ба жендер, ярианы хэв маяг, minimal response, backchannel

Keywords: Mongolian language, Sociolinguistics, Language and Gender, conversational style, minimal response, backchannel

1. Удиртгал. Эрэгтэй, эмэгтэй хүний хэлний хэрэглээний ялгаа, нийгмийн харилцаа, жендерийн дүрийг хэлээр хэрхэн бүтээж байгааг судалдаг нийгэм хэл шинжлэлийн нэг салбар нь хэлний жендерийн судалгаа юм. Энэхүү салбар нь зөвхөн эрэгтэй, эмэгтэй хүний хэл яриаг судлаад зогсохгүй тэдний амьдралын хэв маяг, хандлага, үзэл санааны ялгааг тодруулахыг зорьдог байна. Тиймээс жендерийн ялгаатай байдал нь сэтгэл судлал, нийгэм хэл шинжлэл, эмэгтэйчүүдийн судлал зэрэг олон салбарын дундын судлагдахуун болдог бөгөөд өөр өөр онол, арга зүйгээр судалсаар байна. Хэлний жендерийн судалгаа 1970-аад оны үеэс *Мэри Р.Кэй* (Mary Ritchie Key), *Р.Лакофф* (Robin Lakoff), *Б.Торн* (Barrie Thorne) тэргүүтэй хэл шинжлэлчдийн бүтээлээр эхэлжээ.

Хэл ба жендерийн талаарх үндсэн онолуудын дунд хэд хэдэн нөлөө бүхий үзэл хандлага бий. Тухайлбал: *Р.Лакофф* (Lakoff, 1975) *дутагдлын онол* (Deficit theory)-ыг дэвшүүлж, эмэгтэйчүүдийн хэл эрэгтэйчүүдийнхээс доогуур байр суурьтай гэж үзжээ. Харин *Барри Торн* болон *Нэнси Хенли* (Thorne & Henley, 1975) нар *давамгайллын онол* (Dominance theory)-ыг үндэслэж, хэлэн дэх эрэгтэйчүүдийн давамгайл байдал нь хэлний шинж чанар биш, нийгмийн эрх мэдлийн илэрхийлэл гэж үзсэн бол үүний дараа *Дебора Камерон* (Cameron, 2003) эмэгтэйчүүд нь бусадтай харилцахдаа илүү сайн сонсож, сэтгэл хөдлөлөө илэрхийлэх чадвараар эрчүүдээс илүү байдгийг онцолжээ.

1975 онд *Р.Лакофф*-ын *Language and Woman's Place* хэмээх бүтээл хэвлэгдсэнээс хойш хэл шинжлэлчид хэл ба жендерийн асуудлыг олон талаас судалж ирсэн байна. Тэдгээрийг ерөнхийд нь дараах дөрвөн хандлагад хувааж болно. Үүнд: *дутагдлын хандлага* (deficit), *давуу байдлын хандлага* (dominance), *ялгаат байдлын хандлага* (difference) мөн *хувьсанги буюу нийгмийн бүтээлч хандлага* (dynamic / social constructionist) зэрэг багтана. Эдгээр хандлагууд дараалан хөгжсөн бөгөөд сүүлийнх нь өмнөхөө үгүйсгэлгүй, нэг нь нөгөөгөө нөхөж, зэрэгцэн оршиж иржээ. Гэхдээ өнөө үед олонх судлаач *хувьсанги буюу нийгмийн бүтээлч хандлагыг* голчлон баримталж байна.

Эмэгтэй, эрэгтэй хүний хэлний онцлог болон ярианы хэв маяг (conversational style)-ийн ялгааг монгол хэлний баримтаар судлан тайлбарласан бүтээл “бэрлэж ярих ёс”-ыг эс тооцвол¹ одоогоор хэвлэгдээгүй байна. Тиймээс бид эмэгтэй, эрэгтэй хүний хэл ярианы онцлог, хандлага болон ашигладаг үг хэллэг, ярианы хэв маягийн ялгаа зэргийг монгол хэлний баримтаар тодруулан тайлбарлахыг зорин ажиллаж байгаа билээ. Тус өгүүлэлдээ эмэгтэй, эрэгтэй хүний харилцаа яриан дахь хариу үйлдэл үзүүлэх богино хариулт, үг хэллэг (minimal responses, backchannels)-ийн хэрэглээний онцлогийг авч үзэх болно.

2. Харилцаа яриан дахь хариу үйлдэл үзүүлэх үг хэллэг. Харилцагчийнхаа яриаг дэмжих, санал нийлэх болон сонсож, ойлгож буйгаа илэрхийлэх үед хэрэглэдэг *мхн, ммм, аанхан, тийм...* зэрэг хэлбэрийг “хариу үйлдэл үзүүлэх үг хэллэг” (minimal response, backchannel) гэнэ. *Харви Сакс* (Harvey Sacks) “*мм, за, тийм* зэрэг богино хариулт нь ярьж буй хүний яриаг дэмжих, яриагаа үргэлжлүүлэх дохио болж өгдөг” (1992: 110) гэж тодорхойлсон бол *Гейл Жефферсон* (Gail Jefferson) “яриаг таслахгүйгээр өгүүлэгчийг үргэлжлүүлэн ярихыг дэмжих дохионы үүрэг гүйцэтгэдэг” (1984: 15) гэж тус тус тодорхойлжээ.

П.М.Фишман (Fishman) “эмэгтэйчүүдийн ярианд түгээмэл ажиглагддаг *яриаг дэмжих богино хариу* (minimal response) буюу *yeah, mhm* зэрэг дэмжих хариу үйлдэл дохио нь ярилцаж буй хүмүүсийн хамтын ярианы орчин бүрдүүлэх чухал хэрэглүүр болохоос гадна яриа өрнүүлэх, яригчийг идэвхтэй сонсож буйгаа илтгэх, харилцааны уур амьсгалыг зөөлрүүлэх зэрэг үүрэгтэй” (1980: 127) гэж үзсэн байна. Түүнчлэн эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн харилцаа ярианы зорилго өөр өөр байдаг талаар *Жон Малц* болон *Рут Боркер* (J.Maltz & R.Borker, 1982) нар судалж үзээд “харилцаа ярианы үед жендерийн ялгаанаас шалтгаалж үл ойлголцол үүсэж болно. Эмэгтэй хүний ярианд “*мхн*” хэмээх хэлбэр нь “би сонсож байна” гэдгийг илэрхийлдэг бол эрэгтэй хүний ярианд эл хэлбэр нь “санал нийлж байна” гэсэн утгаар хэрэглэдэг (1982: 202) гэжээ. *Дебора Таннен* (Deborah Tannen) үргэлжлүүлэн судалж ярианы хэв маягийг *харилцах яриа* (rapport talk), *илтгэх яриа* (report talk) гэж ангилаад түүний ялгааг тайлбарлахдаа “эмэгтэйчүүд харилцаа холбоо, эелдэг, ойр дотно байдлыг тогтоох, ярианд дэмжлэг үзүүлэхийн тулд *yeah, mhm, right* зэрэг хариу үйлдэл үзүүлэх хэллэгийг давтамж ихтэй ашигладаг. Эдгээр нь “*би таныг сонсож байна*” гэсэн харилцаа ярианы оролцоог илэрхийлэх дохио болж байдаг (1990: 77-79). “Эрэгтэйчүүдийн хэрэглэж буй хариу үйлдэл үзүүлэх хэлбэрүүд нь ихэвчлэн *ярианд оролцож байна, мэдээллийг хүлээн авлаа* гэсэн утгатай байх бөгөөд энэ нь харилцаа ярианд байр суурь, эрх мэдлээ хадгалах зэрэг зорилго, эрмэлзэлтэй холбоотой” (1990: 82) хэмээн дүгнэсэн байна.

3. Судалгааны хэрэглэгдэхүүн, арга зүй. Энэхүү судалгааг Централ телевиз (Central Television)-ийн 2025 оны “Тэнгисийн эрэг дээрх 24/7”² шоу нэвтрүүлгийн ярианы хөмрөгт тулгуурлаж хийлээ. Тухайн нэвтрүүлгийг судалгааны хэрэглэгдэхүүнээр сонгоход эмэгтэй, эрэгтэй оролцогчийн харьцаа адил тэнцүү, 19-32 насны залуус оролцсон зэрэг нь голлон нөлөөлсөн юм.

¹ Баруун монгол эмэгтэйчүүд зарим үгийг эерүүлэн хэлэхийг “Бэрлэх ёс” хэмээн нэрлэх бөгөөд энэ нь гол төлөв хадам талынхаа ахмад настны нэрийг дуудахаас цээрлэх, авгайлах уламжлалтай холбоотой юм. Монгол эмэгтэйчүүдийн бэрлэж ярих ёсны талаар П.Аалто (1967), Э.Вандуй (1965) нарын судалгаанаас дэлгэрүүлэн үзнэ үү.

² Тус нэвтрүүлгийг 2024 оноос хийж эхэлсэн бөгөөд нэг улирлын дугаарт 20 орчим хүн (панелист болон оролцогч) оролцдог.

Судалгааны эх хэрэглэгдэхүүн болгон нэвтрүүлгийн дүрс бичлэгийг текстэд буулгаж, оролцогчдын яриаг эрэгтэй, эмэгтэйд нь ангилсан 47816 үг бүхий судалгааны хөмрөг үүсгэв. Үгийн давтамж, хэрэглээний онцлогийг *Antconc* программ ашиглан тооцоолж, эрэгтэй эмэгтэй хүний харилцаа ярианд хариу үйлдэл үзүүлэх үг хэллэгийг нарийн ангилан ялгаж, тус бүрийн тоо давтамжийг хүснэгтээр гаргасан бөгөөд тоон судалгааны арга, корпус хэл шинжлэлийн аргачлал, харилцаа ярианы шинжилгээ зэрэг арга зүйг ашигласан болно.

4. Эрэгтэй, эмэгтэй хүний харилцаа ярианд хариу үйлдэл үзүүлэх үг хэллэгийн хэрэглээ. Судалгааны сангаас хайхад харилцаа ярианд хариу үзүүлэх “мхн [m:χ^hn] , аанхан [a:ηχ^hən] (аанха [a:ηχ^ha:], аан за [a:η tsa:]), мм [m:], ммм [m::], ea (yeah) [jæ:], ес (yes) [jes], тийм [tʰi:m] (тий [tʰi:], тийн [tʰi:η], тийм ээ [tʰi:me:], тий тий [tʰi: tʰi:], харин тий [χæɾən tʰi:], харин тийн [χæɾən tʰi:η], харин тийм ээ [χæɾən tʰi:me:], тийм байна [tʰi:m pæ:n], тхх [tʰx^hx^h]” зэрэг үг хэллэг эрэгтэй, эмэгтэй хүний аль алиных нь ярианд тохиолдож байна. Гэсэн хэдий ч хэрэглээний давтамж нь ялгаатай бөгөөд эрэгтэйчүүдийн ярианд 281 удаа, эмэгтэйчүүдийн ярианд 479 удаа хэрэглэгджээ. Харилцаа ярианд хариу үзүүлэх үг хэллэг эмэгтэйчүүдийн ярианд эрчүүдийнхээс давтамж ихтэй байгаа нь П.М.Фишман, Ж.Малц, Р.Боркер, Д.Таннен зэрэг судлаачийн дэвшүүлсэн саналтай нийлж байна.

Харилцаа ярианд хариу үйлдэл үзүүлэх эдгээр үг хэллэг эрэгтэй, эмэгтэй хүний ярианд хэрхэн хэрэглэгдэж буйг авч үзье.

4.1. Харилцаа яриан дахь эмэгтэй хүний “мхн” [m:χ^hn], “аанхан” [a:ηχ^hən] хэлбэрийн хэрэглээ. Монгол хэлний яриа дэмжих богино хариу “аанхан” нь харилцаа ярианд “аанха”, “мхн”, “ммн” болон “ea” (yeah) зэрэг хэд хэдэн хувилбараар илэрч байна.

4.1.а. “мхн”, “аанхан” хувилбар.

(1) -----

Хасаа (эрэгтэй): Тэгэхээр одоо байгаа залуучуудаас хамгийн таалагдаж байгаа нь би гэж үү?

Жэюүн (эмэгтэй): Мхн.

Хасаа (эрэгтэй): Эргэлзэхгүй хэлсэн чинь бас таалагдлаа, шууд “мхн” гэсэн чинь.

Жэюүн (эмэгтэй): Чи яагаад намайг сонгосон юм?

Хасаа (эрэгтэй): ... ерөөсөө тухтай ярих боломж бид хоёрт олдоогүй.

Жэюүн (эмэгтэй): Мхн.

Хасаа (эрэгтэй): Чиний талаар бас мэдмээр байгаа зүйл зөндөө байсан. Бас миний сонирхлыг их татаж байгаа, харц солилцоод эрмэлзэхээс хэтрээгүй болохоор.

Жэюүн (эмэгтэй): Мхн.

(2) -----

Болд (эрэгтэй): Хасаа шиг тодорхой байх хэрэгтэй.

Дүзиймаа (эмэгтэй): Мхн

Болд (эрэгтэй): Одоо тэр чинь шууд тодорхой болгож байна ш дээ.

Дүзиймаа (эмэгтэй): Тий.

Дээрх харилцаа ярианаас харахад эрэгтэй оролцогчийн асуултад хариулахдаа, мөн яриан дундуур харилцагчийнхаа яриаг дэмжихдээ эмэгтэйчүүд гол төлөв “*мхн*” хэлбэрийг ашиглаж байна. Энэхүү яриаг дэмжих богино хариу (minimal response) нь эмэгтэйчүүдийн ярианд түгээмэл ажиглагддаг бөгөөд “ярилцаж буй хүмүүсийн хамтын ярианы орчин бүрдүүлэх чухал хэрэглүүр болохоос гадна яриа өрнүүлэх, яригчийг идэвхтэй сонсож буйгаа илтгэх, харилцааны уур амьсгалыг зөөлрүүлэх” (Fishman, 1980: 127) үүрэгтэй байдаг аж. Энэ нь Д.Таннены тодорхойлсон *харилцах яриа* (rapport talk)-ны онцлог бөгөөд эмэгтэйчүүд хэн нэгэнтэй ярилцахдаа санаа бодлоо солилцонгоо таатай тухтай уур амьсгал бүрдүүлэхийг зорьдогтой холбоотой байна. Өөрөөр хэлбэл, энэ нь эрэгтэй эмэгтэй хүмүүсийн хэл яриа нь өөр өөрийн гэсэн онцлог бүхий шинжүүдтэй хэмээн үзсэн Д.Таннен зэрэг судлаачдын дэвшүүлсэн *ялгаат байдлын онол* (difference)-той тохирч буй юм.

Хувилбар	Жишээ үг	Эрэгтэй	Эмэгтэй	Нийт давтамж
Бүрэн бус дуудлага	мхн [m:χ ^h n]	18	35	54
	ммхн [m:χ ^h η]	0	1	
		Нийт-18	Нийт-36	

Хүснэгт 1. *Мхн, ммхн хэлбэрийн хэрэглээний давтамж*

(3) -----

Хонгор (эрэгтэй): Миний бага нас аягүй хурдан өнгөрчихсөн юм шиг санагддаг. Нүүдэл суудал гэж газар солигдож өөр хот руу яваад.

Дияана (эмэгтэй): Аанхан.

Хонгор (эрэгтэй): Яг тийм удаан хугацааны найз байдаггүй.

Дияана (эмэгтэй): Мхн.

Харин жишээ (3) нь Д.Таннены “эмэгтэйчүүдийн яриан дахь *yeah, mhm, right* зэрэг хариу үйлдэл үзүүлэх хэлбэрүүд нь яриаг дэмжих, “*би таныг сонсож байна*” гэсэн харилцаа ярианы оролцоог илэрхийлэх дохио болж байдаг (1990: 77-79) гэсэн саналтай яг тохирч байна. Өөрөөр хэлбэл, эрэгтэй оролцогч өөрийн таагүй дурсамжийн талаар ярихад эмэгтэй оролцогч түүний яриаг анхааралтай сонсож буйгаа “*аанхан*”, “*мхн*” зэрэг хэлбэрээр илэрхийлж, яриаг дэмжиж байна.

4.1.b. “ммнг” [m:ηq] хувилбар. Яриаг дэмжих богино хариу нь “*аанхан*”, “*мхн*”-аас гадна “*ммнг*” хувилбараар илэрч байна.

(4) -----

Батаа (эрэгтэй): Одоо яг жинхэнээсээ ярьж байна ш дэ, тэ?

Содгэрэл (эмэгтэй): ммнг.

Болд (эрэгтэй): Ингээд яривал бас болж байна ш дэ.

Батаа (эрэгтэй): Энэ залуучууд маань... бид нарт маш гоё сэдэв тэ, одоо юу гэдэг юм харилцаанууд ийм жишээ, үлгэр жишээ тэ?

Дүзиймаа (эмэгтэй): ммнг.

Батаа (эрэгтэй): Болохгүй гэсэн ч одоо тийм жишээнүүдийг харуулж тэ?

Содгэрэл (эмэгтэй): харин тийн.

Батаа (эрэгтэй): Гоё юм аа, ийм юм харахаар ингээд бид нар ч гэсэн нэг ийм романтик мэдрэмж ингээд...

Содгэрэл (эмэгтэй): ммнг.

Батаа (эрэгтэй): Хөглөж байгаа биз, бид нарыг улам романтик байхыг.

Дүзиймаа (эмэгтэй): тийн.

“ммнг” хувилбар эрэгтэйчүүдийн ярианд огт хэрэглэгдээгүй байх бөгөөд зөвхөн эмэгтэйчүүдийн ярианд тохиолдоно. “мхн, аанхан, тий” зэрэгтэй утга, үүрэг нь адилхан боловч арай зөөлөн, эелдэг, илүү эмэгтэйлэг өнгө аясыг илэрхийлж байна. Бас наснаас хамаарсан хэрэглээний ялгаа байж болох ба “ммнг” хувилбар нь 30 болон 41 настай панелистуудын ярианд гарч байна. Наснаас хамаарч хэлний хэрэглээ өөрчлөгддөг бөгөөд үүнийг нийгэм хэл шинжлэлд “насны шатлал” (age grading) гэж нэрлэдэг билээ.

Хувилбар	Жишээ үг	Эрэгтэй	Эмэгтэй	Нийт давтамж
Бүрэн бус дуудлага	ммнг [m:ŋŋ]	0	3	3

Хүснэгт 2. “Ммнг” хэлбэрийн хэрэглээний давтамж

4.1.с. “Еэс (Yes) [jes], ea ea (Yeah) [jæ: jæ:]” хувилбар. Сүүлийн жилүүдэд залуусын хэл ярианд монгол, англи хэлээр код сольж (code switching) ярих үзэгдэл ажиглагдах болсон билээ. Энэ нь хариу үйлдэл үзүүлэх үг хэллэгийн хэрэглээнд ч илрэх бөгөөд түүний баримт нь еэс (yes), ea (yeah) юм. Тухайн үгсийн утга нь адилхан боловч хэрэглэх орчин нөхцөл нь ялгаатай учраас “найруулгын хувилбар” гэж нэрлэх нь бий. Эдгээрийг хэрхэн ашиглаж буйг дараах жишээнээс харъя.

(5) -----

Мока: За хоёр оноо, хоёрдугаар асуулт: “Спонж боб” хүүхэлдэйн кинонд ямар амьтан усны хувцас өмссөн байдаг вэ?

Нацаг (эрэгтэй): Еээ.

Энхтамир: Минж, нөгөө нэг ус ухдаг.

Золоо: ea, ea, Минж.

(6) -----

Дүзиймаа (эмэгтэй): Хасаагүй шүү, Хасаагийн яг үнэн төрхийг нь маш их ажиглаж мэдрээд харсан болохоор л хассан.

Содгэрэл (эмэгтэй): еэс.

Эмэгтэйчүүдийн ярианд “ea” (yeah) 3 удаа тохиолдох боловч эрэгтэйчүүдийн ярианд гарахгүй байна. Дээр дурдсанчлан “yeah” нь “yes” (тийм)-ын хувилбар боловч судлаачдын үзэж байгаагаар *дэмжих хариу үйлдэл* (backchannel)-ийн үүргээр хэрэглэгддэг бөгөөд эмэгтэйчүүдийн яриан дахь *харилцах зорилго бүхий яриа* (rapport-building), *хамтран оролцох хэв маяг* (involvement) зэргийг илэрхийлж, ярьж буй хүний яриаг дэмжих зорилготой (Holmes, 1995: 8; Tannen, 1990: 53-55) байдаг. “yeah” нь албан бус, ярианы хэлэнд түгээмэл тохиолддог хувилбар бөгөөд яриаг дэмжих, хамтран оролцох, харилцаа ярианд ойр дотно уур амьсгалыг бий болгох зэрэг үүрэгтэй байна. Харин “yes” нь ихэвчлэн албан харилцаанд, асуултад тодорхой хариулах үед хэрэглэгдэж (6), мэдээллийг батлах өнгө аясыг илэрхийлдэг аж.

Хувилбар	Жишээ үг	Эрэгтэй	Эмэгтэй	Нийт давтамж
Бүрэн дуудлага	еэс [jes]	2	7	9
Бүрэн бус дуудлага	ea [jæ:]	0	1	3
	ea ea [jæ: jæ:]	0	2	

Хүснэгт 3. “еэс”, “ea, ea, ea” хэлбэрийн хэрэглээний давтамж

4.2. Эрэгтэйчүүд хоорондоо, эмэгтэйчүүд хоорондоо ярилцах үед хэрэглэдэг хариу үйлдэл үзүүлэх үгийн хэрэглээ. Эрэгтэйчүүд болон эмэгтэйчүүд хоорондын харилцаа ярианд нэгнийхээ яриаг дэмжиж буйгаа илэрхийлэх богино хариу үйлдэл үзүүлэх онцлогийн талаар авч үзье.

Охид:

(7) -----

-Золоо (эмэгтэй): Энэ чинь бараг миний ягаан өнгө юм биш үү?

-Жэюүн (эмэгтэй): харин ти.

-Жэюүн (эмэгтэй): Нээрээ л бүр маш их юм болсон тэ?

-Тод (эмэгтэй): тхх, үнэхээр олон юмыг даван тууллаа.

Тод (эмэгтэй): Энэ 2 чинь өчигдөр бүүр намайг даапаалсан шүү дээ.

Жэюүн (эмэгтэй): Ээ үнээн.

Золоо (эмэгтэй): Гүүдэг залуу гэж хэ хэ. Би ингээд Нацагтай юм яриад ингээд үзсэн чинь аймаар бас жентелмэн байсан.

Урин (эмэгтэй): Мхн.

Урин (эмэгтэй): Гэхдээ сүүлийн хэдэн хоног ер нь хэдүүлээ бие биедээ олодохгүй байгаа тэ?

Жэюүн (эмэгтэй): Тийм.

Тод (эмэгтэй): Харин тийм ээ.

(8) -----

Золоо (эмэгтэй): Гэхдээ Тамираа орж ирсэн гэж мэгээд

Тод (эмэгтэй): аанхан.

Урин (эмэгтэй): аанхан.

Залуус:

(9) -----

Трэе (эрэгтэй): Тийм хамгийн наадах чинь конпрэйшн эйнд лов гоод из оф (compression and love gods of) тэ?

Нацаг (эрэгтэй): Тийм, ямар ч гэсэн сүүлийн 2 нь бол Годдес оф сий (gods of sea) тэгээд годдес оф өүшн (gods of ocean) тэгээд Годдес оф Лэйдс (gods of laids) гэсэн үү?

Трэе (эрэгтэй): Тийм, Тэгээд 2 дахь нь болохоороо Годдес оф ноллеж (gods of knowledge).

Нацаг (эрэгтэй): Цаашаа үргэлжлүүлээд явахаасаа өмнө дархлаагаа дэмжээд Гатка Вокс (Gatka Voks) ууя?

Трэе (эрэгтэй): За тэгье.

Тамираа (эрэгтэй): за тэгье.

Охидын хоорондоо ярилцаж буй дээрх хэсэг (7)-т, “харин тий, тхх, аанхан, ээ үнээн, тийм, харин тийм ээ” зэрэг ярианд хариу үйлдэл үзүүлэх, дэмжих илэрхийлэмж олон удаа давтагдаж байхад эрчүүдийн ярианд “тийм, за тэгье” гэсэн үгийг л хэрэглэжээ. Энэ талаар Ж.Коутс (Coates) “эмэгтэйчүүдийн ярианд тухайн сэдвийн талаар хамтран ярилцах ‘мхн, тийм ээ’ зэрэг үг ашиглан бусдын яриаг дэмжих, асуулт асууж яриаг өрнүүлэх, идэвхтэй оролцох зэргээр хамтын ажиллагаанд суурилсан шинжүүд түгээмэл илэрдэг” (1989: 94-122) гэж тэмдэглэсэн нь мөн монгол хэлний баримтаар батлагдаж байна.

Жишээ (8)-д эмэгтэйчүүд бие биетэйгээ ярилцахдаа тухайн сэдэвтэй санал нийлж байгаагаа “аанхан” хэмээх үгийг давтаж, илэрхийлж байна. Эндээс нэгнийхээ яриаг дэмжиж, хамтын оролцоог бүрдүүлж буй шинж илүү илэрч байна. Ж.Коутс “эмэгтэйчүүдийн ярианд хамтын ярианы орчин (collaborative floor) үүсдэг. Эмэгтэйчүүд нэгнийхээ яриаг дэмжин, хамтран үргэлжлүүлж, нөхөх замаар хамтран ярих ярианы орчныг бүрдүүлдэг” (1996: 45-48) гэжээ. Ингэж яриа дэмжиж “мхн, аанхан” зэрэг хэлбэрийг оролцогчид бүгд давтан хэлэх нь хамтын давхацсан яриа (collaborative overlap)-ны онцлогтой нийцэж байна. Дээрх “мхн, аанхан” гэх хэлбэрийн хэрэглээ нь зөвхөн яриаг дэмжих төдийгүй хамтын оролцоог илэрхийлэх хэрэгсэл болдог ажээ. Тодруулбал, эмэгтэйчүүд хоорондын харилцаа ярианд нэгнийхээ яриаг дэмжих, хамтын ярианы орчин бүрдүүлэх, давхцан ярих зэрэг зорилгоор хариу үйлдэл үзүүлэх үг хэллэгийг түгээмэл хэрэглэж, ярианы эелдэг дотно уур амьсгалыг бүрдүүлэхийг эрхэмлэж байх бол, эрэгтэйчүүд эдгээр үгсийг тодорхой асуултад батлан хариулсан, ойлгосон, мэдээллийг хүлээн авсан зэргийг илэрхийлэх тохиолдолд хэрэглэж байгаа нь эрэгтэй, эмэгтэй хүний хэл ярианы нэгэн ялгаатай шинжийн илрэл болно. Энэ нь эмэгтэй, эрэгтэй хүн нийгэм соёлын олон хүчин зүйлийн нөлөөгөөр хэлийг ялгаатай байдлаар хэрэглэдэг хэмээн үздэг ялгаат байдлын онол той нийцэж буй юм. Энэхүү онол нь эрэгтэй, эмэгтэй хүний зан төлөв, нийгмийн хүлээлт, харилцааны зорилго, нийгмийн байр суурь зэрэг олон талт хүчин зүйлээс шалтгаалан хэлийг өөр өөрөөр хэрэглэдэг хэмээн үздэг юм.

4.3. Харилцаа ярианд дахь эрэгтэй хүний “аанхан [a:ŋχʰən], тий [tʰi:], харин тий [χæŋən tʰi:]” хэлбэрийн хэрэглээ. Энд харилцаа ярианд хариу үзүүлэх “мхн”, “аанхан”, “тий”, “харин тий” зэрэг хэлбэр эрэгтэйчүүдийн хэл ярианд хэрхэн хэрэглэгдэж буйг авч үзье.

(10) -----

Тод (эмэгтэй): Гэхдээ яах вэ, дэйт (date) хийхэд ч юм уу, сонирхолтой гоё байгаа.

Цэлмэг (эрэгтэй): Мхн, за за, тэгж ойлголоо, ойлголоо.

(11) -----

Урин (эмэгтэй): Чи сонгочихсон байна.

Энки (эрэгтэй): харин тий, өгчихсөн байна.

Урин (эмэгтэй): Өгчихсөн байна.

Энки (эрэгтэй): Тий ерөнхийдөө.

(12) -----

Нацаг (эрэгтэй): За эхлээд үнсэнэ тэ?

Цэнд (эрэгтэй): тий, эхлээд үнсэнэ.

(13) -----

Золоо (эмэгтэй): Тэгээд одоо нэг хөдөлгөөнтэй ийм тогтворгүй яг ийм плэйер гарууд байдаг ш дэ?

Цэнд (эрэгтэй): аанхан.

Д.Таннен эрэгтэй, эмэгтэй хүний ярианд тус тусын хүйсийг бэлгэддэг илэрхийлэл байдаг тухай дурдаад тэрхүү хэлний илэрхийлэлд ямар ч асуудал байхгүй боловч өөрийн хэв маягаараа харилцагчийнхаа хэв маягийг тайлбарлахад асуудал үүсдэг гэжээ. Энэ нь эрэгтэй, эмэгтэй хүний ярих арга нь өөр өөр гэсэн утгатай юм. Эмэгтэйчүүдийн яриа харилцагчтайгаа сэтгэл зүйн холбоо тогтооход илүү анхаардаг бол эрэгтэйчүүдийн яриа мэдээлэлд чиглэдэг аж. Эл шинжид нь тулгуурлаж эмэгтэй хүний яриаг *харилцах яриа* (rapport talk), эрэгтэй хүний яриаг *илтгэх яриа* (report talk) гэж нэрлэдэг тухай өмнө дурдсан билээ. Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн ярианы хэв маягийн энэхүү ялгааг (өөрөөр хэлбэл, мэдээлэлд анхаарч байна уу, сэтгэл зүйн харилцаанд анхаарч байна уу гэдгийг) мэдэх нь харилцаанд үл ойлголцол үүсэхээс сэргийлдэг ажээ. Эмэгтэйчүүдийн ярианд “*аанхан*”, “*мхн*” зэрэг нь зүгээр л таны яриаг сонсож байгааг илэрхийлэх дохио болдог бол эрэгтэйчүүдийн ярианд ямар утга илтгэж буйг авч үзье.

Жишээ (10)-д дурдсантай адил “*мхн*” хэлбэрийг эрэгтэйчүүд “ойлголоо, тухайн мэдээллийг хүлээж авлаа” гэсэн утгаар түгээмэл хэрэглэсэн байна. Энэ нь Д.Таннены харилцаа яриан дахь “*мхн*” гэх хэлбэр нь эрэгтэйчүүдийн хувьд “мэдээллийг хүлээн авлаа, ойлгож байна” гэсэн санааг илэрхийлдэг гэж тодорхойлсонтой бүрэн нийцэж байна. Үүнийг “*мхн*” гэх хэлбэрийн ард тохиолдож буй “ойлголоо, ойлголоо” (жишээ 10) гэсэн үг тодорхой батлан харуулна. Давтамжийн хувьд эрэгтэйчүүд эл хэлбэрийг 18 удаа, эмэгтэйчүүд 36 удаа хэрэглэжээ. Мөн “*тий*”, “*харин тий*”, “*аанхан*” зэрэг хэлбэрийг асуултад хариулах үед, тодорхой болсон нөхцөлийг ойлгож, мэдэж байгааг илэрхийлэх зэрэгт түгээмэл ашигласан байна.

Үүнээс үзвэл эрэгтэйчүүд харилцаа ярианд “*мхн, аанхан, тий, харин тийн*” зэрэг хэлбэрийг тухайн зүйлийг ойлгосон, мэдээллийг хүлээн авсан, асуултад батлан хариулах, мэдэж буйгаа илэрхийлэх зэргээр хэрэглэж буй нь *Ж.Малц, Р.Боркер* (J.Maltz & R.Borker, 1982) нар “харилцаа ярианы үед эрэгтэй хүн “*мхн*” гэх хэлбэрийг санал нийлж байна гэсэн утгаар хэрэглэдэг” (1982: 202), Д.Таннены “эрэгтэйчүүдийн хэрэглэж буй хариу үйлдэл үзүүлэх хэлбэрүүд нь ихэвчлэн *ярианд оролцож байна, мэдээллийг хүлээн авлаа* гэсэн утгатай байх бөгөөд энэ нь харилцаа ярианы байр суурь, эрх мэдлээ хадгалах зэрэг зорилго, эрмэлзэлтэй холбоотой” (1990: 82) гэх мэтээр тодорхойлсонтой бүрэн тохирч байна. Тодруулбал, эрэгтэйчүүд хариу үйлдэл үзүүлэх хэлбэрийг эмэгтэйчүүдээс бага хэрэглэж, хэрэглэхдээ зөвхөн ойлгосон, мэдээллийг хүлээн авсан, асуултад батлан хариулсан хандлагаар голдуу ашиглаж буй нь тэдний нийгмийн байр суурь, эрх мэдэл, эрэгтэйлэг хэв шинжээ хадгалах, хамгаалах зорилготой холбоотой юм.

Эрэгтэйчүүдийн хувьд хэн нэгэнтэй ярилцахыг мэдлэг, ур чадвараа харуулах талбар гэж үздэг байна. Мэдлэг, ур чадвараа бусдад харуулснаар нийгмийн байр сууриа хамгаалж, улмаар сайжруулж чадна гэж итгэдэг ажээ. Энэ нь эрэгтэй, эмэгтэйчүүдийн хэл яриа нь тухайн хэлний орчин, нийгэм, соёлын хүчин зүйлсийн нөлөө зэргээс шалтгаалан хоорондоо ялгарч байдгийг харуулж буй юм.

Хувилбар	Жишээ үг	Эрэгтэй	Эмэгтэй	Нийт давтамж
Бүрэн дуудлага	аанхан [a:ŋχ ^h ən]	14	10	122
	аан за [a:ŋ tsa:]	2	6	
	аан [a:ŋ]	39	50	
		Нийт-56	Нийт-66	
Бүрэн бус дуудлага	аанха [a:ŋχ ^h a:]	0	4	4
Бүрэн дуудлага	тийн [t ^h i:ŋ]	27	34	121
	тийм байна аа [t ^h i:m pæ:n a:]	4	0	
	тийм байна [t ^h i:m pæ:n]	8	39	
	тийм ээ [t ^h i:me:]	5	4	
		Нийт-44	Нийт-77	
Бүрэн бус дуудлага	тий [t ^h i:]	107	132	260
	тий тий [t ^h i: t ^h i:]	13 Нийт-120	8 Нийт-140	
Бүрэн дуудлага	харин тийм [χærən t ^h i:m]	0	4	11
	харин тийм ээ [χærən t ^h i:me:]	2	1	
	харин тийн [χærən t ^h i:ŋ]	0	4	
		Нийт-2	Нийт-9	
Бүрэн бус дуудлага	харин тий [χærən t ^h i:]	9	56	65
Бүрэн дуудлага	тийм байна [t ^h i:m pæ:n]	12	39	55
	тийм байна аа [t ^h i:m pæ:n a:]	4	0	
		Нийт-16	Нийт-39	

Хүснэгт 4. Харилцаа ярианд дахь эрэгтэй, эмэгтэй хүний “аанхан, тий, харин тий” хэлбэрийн хэрэглээний давтамж

4.4. Холимог бүлэг (эмэгтэйчүүд, эрэгтэйчүүд хоорондын)-ийн харилцаа ярианы үед тохиолдож буй хариу үйлдэл болох “мхн” [m:χ^hn], “тий” [t^hi:], “тхх” [t^hχ^hχ^h], “яг яг” [jaq jaq] зэрэг хэллэгийн хэрэглээ.

(14) -----

Трэе (эрэгтэй): ...бусад хүмүүстэй хааяадаа нэг харьцахдаа, нэг жоохон захирангуй ч юм шиг, Жэюүнийг нэг ингээч тэгээдхээч гээд тиймэрхүү харилцаа нэг жоохон эвгүй мэдрэмж төрүүлсэн болохоор яалт ч үгүй өнөөдөр Дөлгөөнийг алсан байгаа.

Батаа (эрэгтэй): Тийм хүмүүс байдаг тэ?

Болд (эрэгтэй): Тий.

Батаа (эрэгтэй): Гэнэт зараад, ингээд гар хөлийн үзүүрт зараад эхэлдэг тэ?

Болд (эрэгтэй): Тий.

Содгэрэл (эмэгтэй): Харин тий.

Батаа (эрэгтэй): Зүв зүгээр байж байхад, тэрийг аваад өг мөг гээд.
Содгэрэл (эмэгтэй): Тий тий.

Жэюүн (эмэгтэй): Нээрээ л, нээрээ л бүр маш их юм болсон тэ?
Тод (эмэгтэй): Тхх, үнэхээр олон юмыг даван тууллаа.

Содгэрэл (эмэгтэй): Нороогүй юу?
Батаа (эрэгтэй): Тхх, би өнөө орой эхнэрээрээ нэг асгуулна аа.

Батаа (эрэгтэй): Нэг гэмгүй ч юм шиг тэ?
Содгэрэл (эмэгтэй): Яг яг.

Эмэгтэй, эрэгтэйчүүд хоорондын холимог бүлгийн харилцаа ярианы үед тохиолдох хариу үйлдэл нь ихэнхдээ хамтын ярианы өнгө аяс, сэдвийн талаар санал нэгдэж буй зэргийг “мхн”, “тий”, “тхх”, “яг яг” зэрэг хэллэгээр илэрхийлж байгаа нь дээрх жишээнээс харагдаж байна. Үүнийг Ингве (V.H. Yngve)-ийн бичсэн *дэмжих хариу үйлдэл* (backchannel) хэмээх үзэгдлийн үүднээс тодруулж болох юм. Түүний үзсэнээр “сонсогч ярианы ээлжийг бүрэн авч хариулахгүй хэдий ч ярилцаж буй хүнийг үргэлжлүүлэн ярихад дэмжлэг үзүүлэх богино дуу авиа, хэллэг, дохио зангаа гэж тодорхойлсон байдаг ба энэ төрлийн хариу үйлдэлд “мхн”, “тийм”, “за”, “яг тийм” зэрэг дэмжих богино хэллэг, толгой дохих, инээмсэглэх зэрэг дохио зангаа багтдаг” (1970: 569) гэжээ.

Судлаачдын үзэж байгаагаар дэмжих хариу үйлдэл нь ярилцагчдын хоорондын эв нэгдэл, харилцан ойлголцлыг хадгалах, яриаг цааш үргэлжлүүлэх, ярианы өнгө аясыг зөөлрүүлэх зэрэг үүрэг гүйцэтгэдэг аж. Харилцаа ярианы жишээ (14)-ээс үзвэл, тухайн сэдвийн талаар бүгд санал нэгдэж, зарим нь илүү дэлгэрүүлэн тайлбарлаж, бусад нь дэмжиж хариу үйлдэл үзүүлж буй зэрэг нь эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн холимог ярианы орчинд ярьж буй сэдэвтэй санал нэгдэж буй үед дэмжих хариу үйлдлийг эн тэнцүү хэрэглэх тохиолдол байдгийг харуулж байна.

Дээрх жишээнд гарч байгаагчлан “тий”, “тхх”, “яг яг” гэх хэлбэрийг ихэнх тохиолдолд асуултад хариулах үед хэрэглэж байгаа нь мэдээллийг батлах үүрэг нь давамгайл болохыг харуулж байна.

Дүгнэлт

Бид энэхүү өгүүлэлдээ “Тэнгисийн эрэг дээрх 24/7” шоу нэвтрүүлгийн текстийн санд тулгуурлан харилцаа ярианд хариу үйлдэл үзүүлэх үг хэллэгийг эрэгтэй, эмэгтэй хүний хэл ярианд хэрхэн хэрэглэгдэж байгааг судалсан юм. Харилцаа ярианд хариу үйлдэл үзүүлэх “тийн [tʰi:ŋ], тийм ээ [tʰi:me:], тий [tʰi:], тий тий [tʰi: tʰi:], харин тийм [χæɾən tʰi:m], тийм байна (аа) [tʰi:m pæ:n (a:)], мхн [m:χʰn], ммхн [m:χʰŋ], ммнг [m:ŋŋ], аанхан [a:ŋχʰən], аан за [a:ŋ tsɑ:], аан [a:ŋ], аанха [a:ŋχʰa:], мм [m:], ммм [m:::], окее (ok) [ɔkʰej (ɔkʰ)], еэс (yes) [jes], еа [jæ:], еа еа (yeah) [jæ: jæ:], тхх [tʰxʰxʰ], яг яг [jaq jaq]” зэрэг хэлбэр эрэгтэйчүүдийн ярианд нийт 281 удаа давтагдсан бол, эмэгтэйчүүд ярианд 479 удаа тохиолдож байна. Энэ нь эмэгтэйчүүд харилцаа яриандаа хариу үйлдэл үзүүлэх үг хэллэгийг эрчүүдээс илүү хэрэглэдэг болохын баримт болно.

Эрэгтэй хүний ярианд хариу үзүүлж буй эмэгтэй хүний үг хэллэг (аанхан)-ийн хэрэглээний тухайд, ярьж буй зүйлийн талаар санал нэгтэй байгааг, дэмжиж, сонсож буйг илтгэх утга голлож байна. Мөн ижил нөхцөлд ярианы сэдэв нь таагүй байх үед эмэгтэй хүний хариу үйлдэл үзүүлэх хэллэгийн зорилго нь сонсож, мөн ойлгож буйгаа илэрхийлэх дагалт утгатай байна. Харин эрэгтэй, эмэгтэй холимог хүйсийн ярианы орчинд тухайн сэдвийн талаар санал нэгдэж буй үед “тий, тий тий, харин тий, яг яг” гэх хэлбэрээр хамтарсан ярианы өнгө аясыг түлхүү илэрхийлсэн байна.

Эмэгтэйчүүд бие биетэйгээ ярилцахдаа тухайн сэдэвтэй санал нийлж байгаагаа ярианд оролцогч бүр “аанхан” хэмээх үгийг давтан хариулж байгаа нь нэгнийхээ яриаг дэмжих, хамтын оролцоог бүрдүүлэх зэрэг шинж илүү илэрч байна. Энэ нь судлаачдын эмэгтэйчүүд нэгнийхээ яриаг дэмжин, хамтран үргэлжлүүлэх, нөхөх замаар хамтран ярих ярианы орчин нөхцөлийг бүрдүүлдэг гэж үзсэнтэй нийцэж байна. Түүнчлэн зөвхөн эмэгтэйчүүдийн ярианд тохиолдож буй “ммнг” гэсэн хэлбэр байх бөгөөд энэ нь “мхн, тий” зэрэгтэй утга, үүрэг ижил хэдий ч арай зөөлөн, эелдэг өнгө аясыг илэрхийлэх онцлогтой бололтой байна. Мөн эл хэлбэрийн хэрэглээ нь ярилцагчдын насны ялгаанаас хамаарч байж болох юм. “ммнг” хэлбэрийг 30 болон 41 настай эмэгтэйчүүд хэрэглэсэн байна. Мөн эмэгтэйчүүдийн ярианд л хэрэглэгдсэн “ea ea” (yeah) зэрэг хэллэг нь харилцах зорилго бүхий яриа, ярианд хамтран оролцох хэв маягийг илэрхийлж, тухайн хүний яриаг дэмжих зорилгоор хэрэглэгддэг байна.

Эрэгтэйчүүд харилцаа ярианд “мхн, аанхан, тий, харин тий” зэрэг хэлбэрийг тухайн зүйлийг ойлгосон, мэдээллийг хүлээн авсан, асуултад батлан хариулах, мэдэж буйгаа илэрхийлэх зэргээр хэрэглэж буй нь тэдний нийгмийн байр суурь, эрх мэдэл, эрэгтэйлэг хэв шинжээ хадгалах, хамгаалах зорилготой холбоотой ажээ. Харин “тхх”, “яг яг” гэх хэлбэрүүдийг ихэвчлэн асуултад хариулах үед хэрэглэж байгаа нь эдгээр үгэнд мэдээллийг батлах үүрэг нь давамгайл болохыг харуулж байна.

Эцэст нь тэмдэглэхэд, үүсгэсэн эх өгөгдөлд эмэгтэй, эрэгтэй хүний харилцаа ярианд хариу үйлдэл үзүүлэх үг хэллэгийн хэрэглээний ялгааг ажиглахад эмэгтэйчүүд харилцаа яриан дахь “яриа дэмжих богино хариулт буюу хариу үйлдэл үзүүлэх үг хэллэг” (minimal response)-ийг эрэгтэйчүүдээс илүү их хэрэглэж буй нь монгол хэлнээ илрэх хэлний жендерийн ялгаа, онцлогийн нэгэн илрэл болно. Өөрөөр хэлбэл, эмэгтэйчүүд харилцаа ярианд тухайн хүнтэй хамтран ярилцах, харилцах зорилгоор хариу үйлдэл үзүүлэх хэллэгийг түгээмэл хэрэглэж, яриаг цааш өрнүүлэх, дэмжих зэрэг үүрэг гүйцэтгэдэг байхад эрэгтэйчүүд сонсож, ойлгож буйгаа илтгэх, асуултад батлан хариулах, мэдэж буйгаа илэрхийлэхэд хариу үйлдэл үзүүлэх хэлбэрүүдийг ашиглаж байгаа нь тэдний эрх мэдэл, байр суурь, эрэгтэйлэг байдлаа хадгалах, хамгаалах зорилготой холбоотой байдаг аж. Энэ нь Д.Таннен зэрэг судлаачдын дэвшүүлсэн ялгаат байдлын онол-той нийцэж буй юм. Тодруулбал, эрэгтэй, эмэгтэй хүн тухайн нийгэм соёл, хэлний орчинд хэлийг өөр хоорондоо ялгаатайгаар хэрэглэдэг нь тэдний зан төлөв, төрж өссөн орчин, нийгмийн байр суурь, харилцааны зорилго, нийгэмд хэвшин тогтсон ойлголт, нийтийн хүлээлт зэрэг олон талын учир шалтгаантай холбоотой билээ.

Бид тус судалгааг үргэлжлүүлэн хэлний олон талт хэмжүүрээр монгол хэлний жендерийн талаарх үзэл ойлголт, эрэгтэй, эмэгтэй хүний хэл ярианы ялгаа зөрүүг судлах болно.

Ном зүй

- Cameron, D. (2003). *Gender and language ideologies*. In J. Holmes & M. Meyerhoff (Eds.), *The handbook of language and gender*. Blackwell.
- Coates, J. (2015). *Women, men and language: A sociolinguistic account of gender differences in language* (3rd ed.). Routledge.
- Crawford, M. (1995). *Talking difference: On gender and language*. Sage.
- Fishman, P. (1980). *Conversational insecurity*. In H. Giles, W. Robinson, & P. Smith (Eds.), *Language: Social psychological perspectives*. Pergamon Press.
- Gu, L. (2013). Gender differences in language. *Theory and Practice in Language Studies*, 3(2).
- Holmes, J. (1995). *Women, men and politeness*. Longman.
- Humm, M. (1989). *The dictionary of feminist theory*. Prentice Hall.
- Lakoff, R. (1975). *Language and woman's place*. Harper & Row.
- Maltz, J., & Borker, R. (1982). A cultural approach to male-female miscommunication. In J. Gumperz (Ed.), *Language and social identity*. Cambridge University Press.
- Sacks, H. (1992). *Lectures on conversation* (Vols. 1–2). Blackwell.
- Thorne, B., & Henley, N. (1975). *Language and sex: Difference and dominance*. Newbury House.

- West, C., & Zimmerman, D. (1983). Small insults: A study of interruptions in cross-sex conversations. In B. Thorne, C. Kramarae, & N. Henley (Eds.), *Language, gender and society*. Newbury House.
- Yngve, V. H. (1970). On getting a word in edgewise. In M. A. Campbell (Ed.), *Papers from the Sixth Regional Meeting of the Chicago Linguistic Society*. Chicago Linguistic Society.
- Аалто, П. (1967). *Халимаг бүсгүйчүүдийн хэлний тухай*. Монголч эрдэмтдийн анхдугаар их хурлын илтгэлийн эмхтгэл. Улаанбаатар.
- Вандуй, Э. (1965). Дөрвөд аман аялгуу. Улаанбаатар: Шинжлэх Ухааны Академийн хэвлэл.

Abstract

Within the field of sociolinguistics, gendered language variation has been systematically investigated since the 1970s. Numerous studies based on cross-linguistic evidence have demonstrated that male and female speakers exhibit differences at the levels of phonology, grammar, lexicon, and discourse style. However, in the case of Mongolian, empirical research examining gender-based differences in language use-particularly at the level of spoken discourse-remains limited.

Short responses such as *aankhan* [a:ŋχʰən], *mkhn* [m:χʰŋ], *za* [tsa:], and *tiim* [tʰi:m], which are frequently used in conversational interaction, function as discourse-supporting devices known as *minimal responses* or *backchannels*. These forms serve important pragmatic functions, including signaling active listenership, encouraging the speaker to continue, and indicating comprehension or alignment. Despite their significance in discourse, the gendered use of such forms has not yet been systematically examined in Mongolian linguistic research.

This study therefore investigates how minimal responses (backchannel devices) are employed by male and female speakers in conversational interaction. The analysis is based on a spoken corpus drawn from the television program “*Tengisiin Ereg Deerh 24/7*” broadcast by Central Television. The program was selected as research material primarily because it features a balanced proportion of male and female participants, allowing for a reliable gender-based comparison.

The findings indicate that female speakers use backchannel forms more frequently than male speakers in conversational contexts. Moreover, the pragmatic interpretation and perceived meaning of these forms differ according to gender. These results are consistent with the theoretical perspectives proposed by Victor H. Yngve (1970), Judith Maltz and Ruth Borker (1982), Deborah Tannen (1990), and Jennifer Coates (1996) regarding gender differences in conversational style.

Overall, this study represents one of the first empirical attempts to examine gendered discourse patterns in Mongolian and contributes to expanding both the theoretical and practical scope of gender-based sociolinguistic research in the language.

Хавсралт 1.

Эрэгтэй, эмэгтэй хүний харилцан ярианд хариу үйлдэл үзүүлэх үг хэллэгийн нийт давтамжийг үзүүлсэн хүснэгт.

№	Хэмжээс	Хувилбар	Жишээ үг	Эрэгтэй	Эмэгтэй	Нийт давтамж
1.	Харилцан ярианд хариу үйлдэл үзүүлэх үг, хэллэг	Бүрэн дуудлага	тийн [<i>tʰi:ŋ</i>]	27	34	121
			тийм байна аа [<i>tʰi:m pæ:n a:</i>]	4	0	
			тийм байна [<i>tʰi:m pæ:n</i>]	8	39	
			тийм ээ [<i>tʰi:me:</i>]	5	4	
				Нийт-44	Нийт-77	
		Бүрэн бус дуудлага	тий [<i>tʰi:</i>]	107	132	260
			тий тий [<i>tʰi: tʰi:</i>]	13	8	
				Нийт-120	Нийт-140	
		Бүрэн дуудлага	харин тийм [<i>χærən tʰi:m</i>]	0	4	11
			харин тийм ээ [<i>χærən tʰi:me:</i>]	2	1	
			харин тийн [<i>χærən tʰi:ŋ</i>]	0	4	
				Нийт-2	Нийт-9	
		Бүрэн бус дуудлага	харин тий [<i>χærən tʰi:</i>]	9	56	65
		Бүрэн дуудлага	тийм байна [<i>tʰi:m pæ:n</i>]	12	39	55
			тийм байна аа [<i>tʰi:m pæ:na:</i>]	4	0	
				Нийт-16	Нийт-39	
		Бүрэн бус дуудлага	мхн [<i>m:χʰn</i>]	18	35	57
			ммхн [<i>m:χʰŋ</i>]	0	1	
			ммнг [<i>m:ŋq</i>]	0	3	
				Нийт-18	Нийт-36	
		Бүрэн дуудлага	аанхан [<i>a:ŋχʰən</i>]	14	10	122
			аан за [<i>a:ŋ ʈa:</i>]	2	6	
			аан [<i>a:ŋ</i>]	39	50	
				Нийт-56	Нийт-66	
		Бүрэн бус дуудлага	аанха [<i>a:ŋχʰa:</i>]	0	4	4
			мм [<i>m:</i>]	9	18	32
			ммм [<i>m::</i>]	0	5	
				Нийт-9	Нийт-23	
		Бүрэн дуудлага	окэе [<i>ɔkʰej</i>]	2	12	14
			еэс [<i>jes</i>]	2	7	9

		Бүрэн бус дуудлага	ea [jæ:]	0	1	3
			ea ea [jæ: jæ:]	0	2	
				Нийт-0	Нийт-3	
			тхх [<i>t^hχ^hχ^h</i>]	2	3	5
		Бүрэн дуудлага	яг яг [jaq jaq]	1	1	2
			Нийт	281	479	760